

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 12 ДУГААР СУРГУУЛИЙН  
11 ДҮГЭЭР АНГИЙН СУРАГЧДААС АВАХ ГАЗАР ЗҮЙН  
АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

2024.06.07

А хувилбар

Хугацаа 60 минут

Анги бүлэг.....

Нэр: .....

Нэгдүгээр хэсэг

1. Ямар графикаар дүрсэлсэн бэ?

/1 оноо/

- A. Цацраган
- B. Шугаман
- C. Тойргон
- D. Баганан



2. Газарзүйн зурагт харьцангуй тоо хэмжээтэй үзүүлэлтийг зураглалын дараах аргуудаас аль нь илүү тохиромжтой вэ? /1 оноо/

илэрхийлэхэд

- A. Картограммын арга
- B. Цэгийн арга
- C. Картодиаграммын арга
- D. Тэмдгийн арга

3. Хөгжиж буй орнуудын аж ахуйн онцлог аль нь вэ? /1 оноо/

- A. Аж үйлдвэрт олборлох үйлдвэр давуу хөгжсөн
- B. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 80 хувийг үйлдвэрлэдэг
- C. Хөдөө аж ахуй нь эрчимжсэн, ашиг өндөртэй
- D. Аж ахуйн олон салбартай

4. Хөгжиж буй орнуудад хамаарах 3 үзүүлэлтийг сонгоорой.

/1 оноо/

- 1. Хүн амын нөхөн үржихүйн II хэв шинжтэй.
- 2. Тээврийн төрөл олон, замын нягтшил их
- 3. Аж үйлдвэрт олборлох үйлдвэрлэл давуу хөгжсөн.
- 4. Зах зээл дээр түлш, түүхий эд гаргадаг.
- 5. Аж ахуйн олон салбартай.
- 6. Зах зээлд өрсөлдөх чадвар өндөр

- A. 2, 3, 5
- B. 1, 5, 6
- C. 1, 2, 6
- D. 1, 2, 6
- E. 1, 3, 4

5. Өгөгдсөн мэдээллийг уншаад, тохирох утгыг сонгоорой.

/1 оноо/

Индонез улс нь 254.5 сая хүн амтай. Нэг хүнд ногдох ДНБ нь 4700 орчим ам доллар. Энэ нь АНУ-ынхаас бараг 10 дахин бага үзүүлэлт хэдий ч хүн амынх нь хагасаас илүү нь амьдралдаа сэтгэл хангалуун "сайхан" амьдарч байна гэж үздэг ажээ.


- A. Аз жаргалын индекс
- B. Хүний хөгжлийн индекс
- C. Ажиллах хүчний бүтэц
- D. Нэг ажилтны бүтээмжийн хэмжээ
- E. Нэг хүнд оногдох дэд бүтцийн хүчин чадал

6. Хүний хөгжлийн индексийг илэрхийлдэг хэмжигдэхүүнд хамааралтай нь аль вэ? /1 оноо/

- A. Нийгэм дэх иргэдийн оролцоо
- B. Газар зүйн байрлал, орчин
- C. Хүн амын тоо, өсөлт, нягтшил
- D. Цэвэр усны хангамж, хүртээмж
- E. Бичиг үсэгт тайлагдсан байдал

7. Дараах зурагт 2-ын тоогоор тэмдэглэсэн хүн амын нягтшил өндөртэй бүс нутгийг нэрлэнэ үү. /1 оноо/

- A. Өмнөд Африк
- B. Зүүн ба Зүүн Өмнөд Ази
- C. Баруун Европ
- D. Өмнөд Ази
- E. Төв Америк



8. Дэлхийн эдийн засагт гүйцэтгэж буй үүрэг, ач холбогдол өндөртэй бета (гол) зэрэглэлд хамаарах хотыг сонгоорой. /1 оноо/

A. Сан-Франциско    B. Токио    C. Мельбурн    D. Манчестер    E. Тегеран

9. Хүн амын нөхөн үйлдвэрлэлийн 2-р хэв шинж аль нь вэ?

/1 оноо/

- A. Төрөлт, нас баралт аль аль нь өндөр
- B. Төрөлт өндөр, нас баралт бага
- C. Төрөлт, нас баралтын аль аль нь бага
- D. Төрөлт бага, нас баралт өндөр

10. Малави улсын хүн амын дундаж наслалт ДОХ-ын өвчлөл гарахаас өмнө 69 байсан бол өвчлөлийн дараагаар 2015 онд 37 болж буурчээ. Хэдэн хувиар буурсныг тооцоолоорой.

/2 оноо/

- A. 65.0%
- B. 46.4%
- C. 32.0%
- D. 53.0%
- E. 25.5%

11. Хүн амын суваргуудаас 3 дугаартай зурагт тохирох дүгнэлтийг сонгоорой. /2 оноо/



- A. Төрөлт өндөр, нас баралт буурах тул дунд насныхан бага, дундаж наслалт аажим уртасна.
- B. Төрөлт өндөр, бүх насны бүлэгт нас баралт ихтэй, дундаж наслалт богино байна.
- C. Төрөлт буурч зогсонги болно. Нас баралт багасан дундаж наслалт уртсаж өндөр настны эзлэх хувь нэмэгдэнэ.
- D. Төрөлт буурч, нас баралт багасна. Дундаж наслалт багасаж, ахмад насныхны эзлэх хувь буурна.
- E. Төрөлт өндөр, нас баралт ихсэж, дундаж наслалт багасаж, ахмад настны эзлэх хувь өснө.

12. Цагаан арьстан ба шар арьстаны дундаас гарсан холимог арьстаныг сонгоно уу. /2 оноо/

- A. Мулат    B. Самбо    C. Аброген    D. Метис

13. Аль нь Христосын шашны урсгал вэ? /2 оноо/

- A. Суннизм    B. Протестант    C. Махаяана    D. Жүүд

14. Иргэн Бат шинэ байр худалдаж авч, хотын захын хорооллоос хотын төвд нүүж ирэв. Энэ нь хот төлөвлөлтийн "Орон сууцаа сайжруулж буй бүс"-д хамаарах тул олон цөмт загварын аль тоон утгад тохирох вэ? /2 оноо/

- A. 9    B. 1    C. 5    D. 8    E. 7




15. Тоон үзүүлэлтийг ашиглан орхигдсон бүс нутгийн хүн амын эзлэх хувийг тодорхойлно уу. /2 оноо/





- A. 13.5%
- B. 12.5%
- C. 14.5%
- D. 15.5%
- E. 11.5%

16. Хүн амын ихэнх хувийг 30-60 насныхан эзэлдэг, дундаж наслалт өндөртэй, төрөлт буурснаас шалтгаалж хүн амзүйн хямралд орсон улсыг сонгоно уу. /2 оноо/



17. Газар тариалан эрхлэхэд шаардлагатай байгалийн хүчин зүйл аль нь вэ? (1 оноо)  
 А. Ажиллах хүч      В. Хөрсний үржил шим  
 С. Техник технологи      D. Усжуулах технологи      E. Зах зээлийн нөлөө
18. Органик фермийн тариалангийн талбайн хэмжээгээр тэргүүлэгч Европ тивийн орнуудыг сонгоно уу. /1 оноо/  
 А. Норвеги, Франц      В. Испани, Итали      С. Герман, Албани  
 D. Итали, Швед      E. Испани, Латви
19. Эрчимжүүлсэн хөдөө аж ахуйн онцлог аль нь вэ? (1 оноо)  
 А. Их хэмжээний газар нутаг шаардагдахгүй  
 В. Усжуулалтын систем шаардагдахгүй.  
 С. Нэгжээс гарах ашиг шим бага  
 D. Хөрөнгө их зарцуулж бага ашиг өгдөг  
 E. Уламжлалт, гар ажиллагааны багаж хэрэгсэлтэй
20. Дараах зурагт ХАА-н /Хөдөө аж ахуй/ салбарт ажиллагсдын эзлэх хувь ба нэг хүнд ногдох ҮНБ-ний /Үндэсний нийт бүтээгдэхүүн/ хамаарлыг цэгэн тархалтат диаграммаар дүрсэлжээ. Диаграммыг ажиглаж зөв дүгнэлтийг олоорой. /2 оноо/  
 А. Нэг хүнд ногдох ҮНБ нэмэгдэх тутам ХАА-н салбарт ажиллагсдын эзлэх хувь багасч байна.  
 В. Нэг хүнд ногдох ҮНБ бага байх тутам ХАА-н салбарт ажиллагсдын эзлэх хувь аажим багасч байна.  
 С. Нэг хүнд ногдох ҮНБ бага байх тутам ХАА-н салбарт ажиллагсдын эзлэх хувь бага байна.  
 D. Нэг хүнд ногдох ҮНБ нэмэгдэх тутам ХАА-н салбарт ажиллагсдын эзлэх хувь өндөр байна.  
 E. Нэг хүнд ногдох ҮНБ бага байх тутам ХАА-н салбарт ажиллагсдын эзлэх хувь 0-тэй ойр байна.
21. Хоёрдогч үйлдвэрийн салбарт аль нь орох вэ? (1 оноо)  
 А. Боловсролын үйлчилгээ      В. Нийтийн үйлчилгээ  
 С. Загасны аж ахуй      D. Үр тарианы аж ахуй      E. Хар төмөрлөгийн үйлдвэр
22. Аж үйлдвэрийг байршуулахад нөлөөлөх нийгмийн хүчин зүйлийг сонгоно уу. /1 оноо/  
 А. Эрчим хүч      В. Түүхий эд      С. Байршил      D. Ажиллах хүч      E. Гол мөрөн
23. Их Британи дахь чихрийн нишингэ боловсруулах үйлдвэрт нийлүүлсэн түүхий эдийн 90%-н алдагдал болдог. Алдагдлыг багасгахын тулд элсэн чихрийн үйлдвэрийг хаана байршуулах нь ашигтай вэ? /1 оноо/



- А. Дэд бүтэц сайтай газар байршуулах  
 В. Зах зээлтэй ойр байршуулах  
 С. Түүхий эдтэй ойр байршуулах  
 D. Ажиллах хүчний нөөцөө түшиглэх  
 E. Байгалийн нөхцөлийг харгалзах

24. Улаанбаатар хотыг баруун аймагтай холбосон Хангайн нурууны араар явдаг замд дайрах хотуудыг зөв дараалуулсан хариуг олно уу. (1 оноо)
- A. Улаанбаатар-Мандалговь-Арвайхээр-Баянхонгор
  - B. Улаанбаатар-Арвайхээр-Баянхонгор-Алтай
  - C. Улаанбаатар-Чойр-Мандалговь-Алтай
  - D. Улаанбаатар-Цэцэрлэг-Тосонцэнгэл-Улиастай
  - E. Улаанбаатар-Мандалговь-Даланзадгад-Алтай

25. Харилцаа холбооны чиглэлээр ажилладаг компаниудыг үйл ажиллагааны чиглэлтэй нь зөв харгалзуулна уу. /1 оноо/

№	Компаний нэр		Үйл ажиллагааны чиглэл
1	SAMSUNG	a	Харилцаа холбоо
2	VODAFONE	b	e-худалдаа
3	MICROSOFT	c	Гар утас
4	AMAZON	d	Мэдээллийн технологи

- A. 1c, 2a, 3d, 4b
- B. 1c, 2b, 3d, 4a
- C. 1d, 2b, 3c, 4a
- D. 1a, 2b, 3c, 4d
- E. 1b, 2c, 3a, 4d


26. Панамын сувгаар холбогдсон усан замыг сонгоно уу. /2 оноо/

- A. Балтийн тэнгис, Хойд мөсөн далайг холбосон усан зам
- B. Газар Дундын тэнгис, Улаан тэнгисийг холбосон усан зам
- C. Газар Дундын тэнгис, Атлантын далайг холбосон усан зам
- D. Номхон далай, Атлантын далай хоёрыг холбосон усан зам
- E. Энэтхэгийн далай, Номхон далайг холбосон усан зам

27. Аялал жуулчлалын үзмэрийг байгалийн ба хүний гараар бүтээгдсэн гэж 2 ангилдаг. Монгол орны аялал жуулчлалын хүний гараар бүтээгдсэн үзмэрүүдээс зөв нэрлэснийг сонгоорой. /2 оноо/

- A. Хамрын хийд, Ээж мод, Алтай таван богд
- B. Богд хааны ногоон ордон музей, Увс нуур, Ёлын ам
- C. Элсэн тасархай, Тэрхийн цагаан нуур, Хоргын тогоо
- D. Эрдэнэ зуу хийд, Буйр нуур, Найман нуур
- E. Чингис хаан музей, Цонжин болдог, Зайсан толгой

28. Аливаа ачааг тээвэрлэх зайнаас хамаарч усан, авто, төмөр замын зардал хэрхэн өөрчлөгдөх вэ? (2 оноо)




- A. Дундын зайд хамгийн их өртөгтэй нь усан замын тээвэр
- B. Холын зайд хамгийн бага өртөгтэй нь авто замын тээвэр
- C. Холын зайд хамгийн бага өртөгтэй нь төмөр замын тээвэр
- D. Богино зайд хамгийн бага өртөгтэй нь усан замын тээвэр
- E. Богино зайд хамгийн бага өртөгтэй нь авто замын тээвэр

29. Улаанбаатар хотоос Увс аймаг руу 50 тн ачаатай машин гарсан бөгөөд нийт 1500 км явсан бол ачаа эргэлтийг олно уу. (E=A\*S) (2 оноо)

- A. 7500 тн.км
- B. 750000 тн.км
- C. 1550 тн.км
- D. 75 000 тн.км
- E. 1450 тн.км

30. Температур болон тунадасны харьцааг ажиглан уур амьсгалын ямар бүс болохыг тодорхойлоорой. /1 оноо/



- A. Экваторын бүс
- B. Тропикийн бүс
- C. Туйлын бүс
- D. Хээрийн бүс
- E. Цөлийн бүс

31. Одоогийн байдлаар дэлхий дээр 40 гаруй улс оронд 2 тэрбум гаруй хүн ам усны хомсдолд ороод байна. Усны хомсдолд нөлөөлдөг нийгмийн хүчин зүйлийг сонгоно уу. /1 оноо/

- A. Усны эх үүсвэрийн нягтшил
- B. Улс орны хөгжлийн түвшин
- C. Чийг тунадасны хэмжээ
- D. Гадаргын хурдас чулуулгийн шинж чанар

Е. Гүний хурдас чулуулгийн шинж чанар

32. Хүлэмжийн хийг бууруулах арга замыг тодорхойлсон 3 зөв хариултыг сонгоно уу. /2 оноо/

1. Мод тариалалтыг нэмэгдүүлэх
2. Малын тоо толгойг өсгөх
3. Зохистой хэрэглээ
4. Хог хаягдлыг нэмэгдүүлэх
5. Усыг зохисгүй хэрэглэх
6. Сэргээгдэх эрчим хүчийг ашиглах

A. 3, 4, 6      B. 1, 2, 5      C. 1, 3, 4      D. 1, 4, 5      E. 1, 3, 6

33. Монгол Улс Парисын хэлэлцээрийг УИХ-аар хэлэлцэн 2016 онд соёрхон баталсан. Хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулахад бидний зүгээс оруулах хувь нэмэрт тохирох хариултыг олно уу. /2 оноо/

- A. Гар утсаараа тоглож, тогтмол цэнэглэх
- B. Аяга тавгаа угаахдаа усанд тосож угаах
- C. Зурагтаа залгуураар нь салгаж унтраах
- D. Бензин хөдөлгүүртэй машин сонгож унах
- E. Крантаа дутуу хааснаас байнга ус дуслах

34. Хүн ам нь ундны усны хомсдолд орсон Ази тивийн улсуудыг сонгоно уу. /2 оноо/



- A. Афганистан, Камбож, Лаос
- C. Лаос, Перу, Индонез
- E. Ирак, Румын, Пакистан

- B. Саудын Араб, Этиоп, Энэтхэг
- D. Камбож, Филиппин, Мавритан

35. Өгөгдлийг уншаад ямар үзэгдлийн тухай мэдээлэл болохыг тодорхойлоорой. /2 оноо/

*Хойд мөсөн далайн мөсөн бүрхүүлийн талбай 1960 оноос хойш 15 хувиар багассан ба зузаан нь 40 хувиар хорогджээ. Үүний шалтгаан нь сүүлийн 10 жилд Хойд мөсөн далайн усны температур  $3^{\circ}\text{C}$  – аар нэмэгдсэн явдал юм. Судлаачдын үзсэнээр Арктикийн цас мөс хайлалтаас болж туйлын зүгээс ирэх далайн хүйтэн урсгал эрчимжих ба энэ нь дулаан урсгалыг саармагжуулж Европт  $5^{\circ}\text{C}$ - аар температур буурах тооцоо гарчээ.*

- A. Цаг агаарын өөрчлөлт
- B. Геологийн өөрчлөлт
- C. Хөрсний доройтол
- D. Уур амьсгалын өөрчлөлт
- E. Уул үүсэх хөдөлгөөн

36. Галт уулын дэлбэрэлтээс агаарт хумхийн тоос ихээр нэмэгдэж тэр нь нарны цацрагийг саатуулж байснаас дэлхийн уур амьсгал хүйтэрч, мөстлөг явагджээ. Энэ нь газар зүйн бүрхэвчийн ямар шинж чанарыг илэрхийлж байна вэ? /1 оноо/

- A. Бүс бүслүүрлэг шинж
- B. Өөрийгөө зохицуулах шинж
- C. Мөчлөг ба хэмнэлтийн шинж
- D. Тасралтгүй нэгдмэл байх шинж
- E. Эргэлтэнд байх шинж

## Хоёрдугаар хэсэг

2.1 Ардчиллын индексээр тэргүүлэгч 3 улсыг нэрлэж бич. /3 оноо/

The Economist Intelligence Unit's 2020 Democracy Index  
167 countries scored on a scale of 0 to 10 based on 60 indicators



Source: The Economist Intelligence Unit

1..... 2..... 3.....

**2.2** Хүснэгтэд зарим бүс нутгууд, тэдгээрийн нийт хүн ам, хотын хүн, хотын ядуусын тоог үзүүлэв. (Аравны нарийвчлалаар тооцоорой) /3 оноо/

Зарим бүс нутаг	Нийт хүн ам (сая)	Хотын хүн ам (сая)	Хотын ядуусын тоо (мянга)
Европ	726	534	33062
Хойд Африк	146	76	21355
Саб- Сахарын Африк	667	231	166208
Латин Америк ба Карибын тэнгисийн орнууд	527	399	127567
Зүүн Ази	1364	533	193824
Зүүн өмнөд Ази	530	203	56781

- а. Зүүн Азийн бүс дэх хотын хүн амын эзлэх хувийг тооцоолоорой. [ab.c] /1.5 оноо/  
б. Зүүн Азийн бүсийн хотын нийт хүн амд ядуусын эзлэх хувийг тооцоолоорой. [de.f] /1.5 оноо/

**2.3** Үндэстэн дамнасан корпорациудыг төрөлжилттэй нь зөв харгалзуулна уу. /3 оноо/ /Зөв үүссэн харгалзаа бүр 0.5 оноотой/

ҮДК		Төрөлжилт	
a	Adidas (адидас)	1	Ундаа
b	Ikea (икеа)	2	Машин
c	Pepsi (пепси)	3	Сүлжээ дэлгүүр
d	Toyota (тоёота)	4	Спортын хувцас, хэрэглэл
e	KFC (кэй эф си)	5	Гоо сайхны бүтээгдэхүүн
f	Microsoft (майкрософт)	6	Түргэн хоол
		7	Программ хангамж

**2.4** Асуулт болгон 2 хэсгээс бүрдэнэ: Нийт 4 оноо

Эхлээд сонгох тестийг анхааралтай уншаад “зөв” гэж үзсэн нэг хариултыг дугуйлна. Дараа нь яагаад зөв гэснээ батлахын тулд хоёр дахь хэсэгт бичсэн хариултын аль нэгийг сонгож дугуйлна. Хэрэв өөрөөр тайлбарлах бол “Бусад” гэсэн хэсэгт нэмж бичнэ.

Хариултыг 1.А.А; 2.Б.Г гэх мэтээр бичнэ. Тоо-тестийн дугаар; эхний үсэг-эхний хариултын аль нэг нь; сүүлийн үсэг-Яагаад гэсэн шалтгаанаас сонгосон үсэг болно.

1. Уур амьсгалын өөрчлөлт бол байгалийн үзэгдэл юм.

- А. Зөв                      Б. Буруу

Яагаад гэвэл:

- А. Уур амьсгалын өөрчлөлт бол дан ганц хүний үйл ажиллагааны нөлөө юм.  
Б. Хар салхи зэрэг гамшигт үзэгдлүүд үүсэх нь зөвхөн байгалийн шалтгаантай.  
В. Дэлхийн уур амьсгал сая сая жилийн туршид өөрчлөгдсөөр ирсэн. Энэ өөрчлөлт одоо ч үргэлжилж байна.  
Г. Бусад .....

2. Ой мод огтлох (ойгүйжилт)-ыг зогсоовол уур амьсгалын өөрчлөлтийг удаашруулна.

- А. Тийм                      Б. Үгүй

Яагаад гэвэл:

- А. Модыг их хэмжээгээр огтолсноор ойд шингэх нүүрсхүчлийн хийн хэмжээ багасна.  
Б. Ойгүй болсон газрын хөрсөнд нарн гэрлийн нөлөөгөөр нүүрстөрөгчийн исэлдэлт явагддаг.  
В. Дээрх 2 хариулт аль аль нь зөв  
Г. Дээрх 2 хариулт аль аль нь биш

СУРГУУЛИЙН УЛСЫН ШАЛГАЛТЫН КОМИСС

Материал зассан багш: